



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 332

Улаанбаатар хот

“Грийт секьюритис” ХХК-ийн
тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 30.1.2, 63.1.5 дахь заалт болон Хорооны 2013 оны 506 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 11.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Грийт секьюритис” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. “Грийт секьюритис” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авах, баримт хүлээлцэх ажлыг зохион байгуулж, арилжаа эрхлэх, төлбөр тооцоо хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын төлөөлөл бүхий комисс томилон ажиллуулахыг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/-т үүрэг болгосугай.


3. Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон компанийн хэлцлийн жагсаалтыг үндэслэн харилцагчийн үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаатай холбоотой баримтыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/, арилжаа болон санхүүгийн баримтыг “Монголын хөрөнгийн бирж” ХХК /Д.Ангар/-д өөрийн байгууллагын архивт хүлээн авахыг тус тус үүрэг болгосугай.

4. Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсонтой холбогдуулан харилцагчийн арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн баримтыг “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 12.9 дэх хэсэгт заасны дагуу цэгцлэн архивын нэгж болгон арилжаа эрхлэх болон төлбөр тооцоо хадгаламжийн байгууллагын архивт хүлээлгэн өгөхийг “Грийт секьюритис” ХХК /Б.Өлзийбаяр/-д үүрэг болгосугай.

5. Тус компанийн харилцагчдыг брокер дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй бусад компанид шилжүүлэх асуудлыг Хорооны 2008 оны 221 дүгээр тогтоолоор батлагдсан “Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон брокер, дилерийн компанийн харилцагчдыг шилжүүлэх журам”-ын дагуу зохион байгуулахыг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/-т үүрэг болгосугай.

6. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийт, харъяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт 15 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

00 332